



МОНГОЛ УЛСЫН САЙД,
ОЛИМП, НИЙТИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН
ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 03 сарын 29 өдөр

Дугаар А/06

Улаанбаатар хот

Төлбөртэй үйлчилгээний журам,
үйлчилгээний төрөл, үнийн жагсаалт
батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, 24.4, 24.5 дахь хэсэг, Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2017 оны 264/А/293 тушаал, Засгийн газрын 2020 оны 136 дугаар тогтоолын хавсралт “Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төв” улсын төсөвт үйлдвэрийн газрын дүрмийн 3.2.1, 3.2.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төвийн төлбөртэй үйлчилгээ үзүүлэх журам”-ыг нэгдүгээр, “эрдэм шинжилгээ, сургалт, судалгааны чиглэлээр үзүүлэх төлбөрт үйлчилгээний төрөл, төлбөрийн хэмжээ”-г хоёрдугаар, “анагаах ухааны чиглэлээр үзүүлэх төлбөртэй тусламж үйлчилгээний төрөл, төлбөрийн хэмжээ”-г гуравдугаар хавсралтаар тус тус баталж 2023 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдөн ажилласугай.

2.Журмыг хэрэгжүүлж, төлбөртэй үйлчилгээг чанартай, хүртээмжтэй байхаар зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Анагаах ухааны албаны дарга (Б.Булган), Эрдэм шинжилгээ, сургалт, судалгааны албаны дарга (Б.Батцэнгэл) нарт даалгасугай.

3.Төлбөртэй үйлчилгээний орлогыг холбогдох журмын дагуу төсөвт төвлөрүүлэх, зарцуулах, нягтлан бодох бүртгэлд тусгаж тайлагнаж ажиллахыг Ерөнхий нягтлан бодогч (Д.Оюунцэцэг)-д үүрэг болгосугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, аж ахуйн албаны дарга (Б.Оргил)-д үүрэг болгосугай.

Монгол Улсын сайд, Олимп,
нийтийн биеийн тамир, спортын
Үндэсний хорооны дарга



Б.БАТ-ЭРДЭНЭ

000507

Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны даргын 2023 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 106 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



СПОРТЫН АНАГААХ УХААН, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ТӨЛБӨРТЭЙ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмын зорилго нь Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төв (цаашид "Төв" гэх) улсын төсөвт үйлдвэрийн газрын зүгээс биеийн тамир, спортоор хичээллэгч хувь хүн, биеийн тамир, спортын болон бусад чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагад спортын шинжлэх ухааны сорил, тест, судалгаа, сургалтын үйлчилгээ болон анагаах ухааны тусламж, үйлчилгээг төлбөртэй үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Төвийн төлбөрт үйлчилгээнээс олсон орлого нь Монгол улсын Төсвийн тухай хууль болон холбогдох журмын дагуу төвийн үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогод хамаарах бөгөөд уг орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавихад энэ журмыг мөрдөнө.

1.3. Төвийн үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлого буюу төлбөрт үйлчилгээнээс олсон орлогын зарцуулалт, тайлагналтыг Төрийн сангаар дамжуулан гүйцэтгэнэ.

1.4. Энэ журам нь Монгол улсын үндэсний шигшээ багийн тамирчдад үзүүлэх аливаа үйлчилгээнд хамаарахгүй.

Хоёр. Төлбөрт үйлчилгээ, түүний төрөл

2.1. Төвийн зүгээс үзүүлэх төлбөрт үйлчилгээг дараах үндсэн төрөлд хуваана.

2.1.1 Спортын шинжлэх ухааны судалгаа, сургалт, сорил шинжилгээний үйлчилгээ;

2.1.2 Эмнэлгийн тусламж, үйлчилгээ.

2.2. Энэ журмын 2.1.1-т заасан төлбөрт үйлчилгээнд спортын шинжлэх ухааны захиалгат судалгаа, сургалт, эрдэм шинжилгээний сорил, тест авах, дүгнэлт гаргах, зөвлөгөө, зөвлөмж өгөх үйлчилгээнүүд хамаарна.

2.3. Энэ журмын 2.1.2-т заасан эмнэлгийн тусламж үйлчилгээнд эмнэлгийн нарийн мэргэжлийн эмчийнүзлэг, анхан шатны тусламж, оношилгоо, эмчилгээ, сувилахуйн болон сэргээн засахын эмчилгээ үйлчилгээ хамаарна.

Гурав. Төлбөрт үйлчилгээ үзүүлэхэд тавигдах шаардлага, орлогын зарцуулалт

3.1. Төлбөрт үйлчилгээний жагсаалт болон үнийн тарифыг үйлчлүүлэгчдэд ил харагдах байдлаар төвийн угтах үйлчилгээний хэсэгт байрлуулахаас гадна төвийн албан ёсны цахим хуудсанд нийтэлнэ.

3.2. Төлбөрт үйлчилгээний талаарх бүхий л мэдээллийг угтах үйлчилгээний цахим бүртгэлийн ажилтан хариуцна.

3.3. Төлбөрт үйлчилгээний орлогыг бэлэн болон бэлэн бусаар байгууллагын кассаар эсхүл дансаар хүлээн авч, үндсэн үйл ажиллагааны орлогын бүртгэлд бүртгэх, байгууллагын Төрийн сан дахь нэмэлт дансанд төвлөрүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих ажлыг Захиргаа, аж ахуйн алба хариуцан зохион байгуулна.

3.4. Үйлчлүүлэгчийн төлбөр төлсөн баримтад байгууллагын нэр, үзүүлсэн тусламж, үйлчилгээний төрөл, төлбөл зохих нийт болон үйлчилгээний нэг бүрийн төлбөрийн хэмжээ, он сар өдрийг тэмдэглэсэн байна.

3.5. Төлбөрт үйлчилгээний орлогыг "Төсвийн тухай хууль" болон Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-д заасны дагуу төсвийн жилийн дундуур шинээр бий болсон орлогод тооцох бөгөөд дараах эрэмбийн дагуу зарцуулна.

3.5.1 Эх үүсвэр дутагдаж байгаа, эсхүл өр төлбөр үүссэн үндсэн үйл ажиллагааны урсгал зардлыг санхүүжүүлэх;

3.5.2 Байгууллагын хамт олон, ажилтныг ажлын үр дүнг нь харгалзан урамшуулах;

3.5.3 Нийт ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэх.

3.6. Энэ журмын 3.5.2, 3.5.3-т заасан зарцуулалтаар зарцуулах хөрөнгийн нийт хэмжээ төлбөрт үйлчилгээний орлогын нийт дүнгийн 60 хувиас хэтрэхгүй байна.

3.7. Төлбөрт үйлчилгээний орлогыг дараах эрэмбийг баримтлан хөрөнгийн зардалд зарцуулна.

3.7.1 Тухайн салбар болон байгууллагын үйл ажиллагаанд нэн тэргүүнд шаардагдах техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, урсгал засварын ажил;

3.7.2 Эдэлгээний хугацаа, дууссан тавилга, эд хогшлыг шинэчлэх;

3.7.3 Байгууллагын их засвар, бусад хөрөнгийн зардал.

3.8. Төлбөрт үйлчилгээний орлогыг зарцуулах хүсэлтийг Сангийн яам хүлээн авч хянасны үндсэн дээр тухай бүр нэмэлт төсвийн зарцуулалтын эрх нээж санхүүжүүлнэ.

3.9. Төв нь спорт, эрүүл мэнд, эрдэм шинжилгээ, судалгааны чиглэлээр үндсэн үйл ажиллагаагаа явуулдаг төсөвт байгууллага тул төлбөрт үйлчилгээний орлогыг энэ журмын 3.8-д заасны дагуу санхүүжүүлнэ.

Дөрөв. Төлбөрт үйлчилгээний орлогыг нягтлан бодох бүртгэлд тусгах

4.1 Төлбөрт үйлчилгээнээс олсон орлого, түүний зарцуулалтыг сар, улирлын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, санхүүгийн байдлын тайлан, орлого, зарлагын явцын мэдээнд оруулж, тухайн тайлант оны санхүүгийн болон үр дүнгийн тайланд тусгана.

4.2 Энэ журмын 4.1-т заасан төлбөрт үйлчилгээний орлого, зарлагатай холбоотой тайлан, мэдээг Төсвийн тухай хууль болон холбогдох журмын дагуу тогтоосон хугацаанд гарган Сангийн яаманд хүргүүлнэ.

Тав. Төлбөртэй тусламж үйлчилгээний төлбөрийн хэмжээг тогтоох

5.1 Төвийн зүгээс үзүүлэх төлбөрт үйлчилгээний төрөл болон төлбөрийн хэмжээг энэ журмын хавсралтад заасны дагуу тогтооно.

5.2 Байгууллагын төлбөрт үйлчилгээний өртөг, зардлын тооцоонд үндэслэн, төлбөрт үйлчилгээний нэр төрөл, хэмжих нэгж, үнэ тарифыг өөрчлөх, хасах, нэмэх тохиолдолд холбогдох хууль тогтоомжийг үндэслэн Олимп, нийтийн биеийн тамир, спортын сайдын тушаалаар батална.

Зургаа. Хувь хүн, аж ахуйн нэгж, байгууллагад гэрээний үндсэн дээр үзүүлэх төлбөрт үйлчилгээ

6.1. Төв нь хувь хүн, аж ахуйн нэгж, байгууллагатай төлбөрт үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулан ажиллаж болох бөгөөд энэ тохиолдолд үйлчилгээний төлбөрийг энэ журмын хавсралтад заасан үйлчилгээний төрөл, төлбөрийн хэмжээг үндэслэн харилцан зөвшилцөж тогтооно.

6.2. Аж ахуйн нэгж байгууллагатай гэрээний үндсэн дээр үзүүлэх төлбөрт үйлчилгээг төвийн дарга болон харьяалах алба хариуцан зохион байгуулна.

6.3. Төв нь өөрийн үндсэн үйл ажиллагааны хүрээнд гэрээний дагуу төлбөрт үйлчилгээг авах хүсэлтэй аж ахуйн нэгж, байгууллагын бичгээр гаргасан хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэснээр холбогдох гэрээг байгуулж, урьдчилан баталсан захиалга, хуваарийн дагуу үйлчилгээ үзүүлнэ.

6.4. Аж ахуйн нэгж байгууллага нь гэрээнд заасны дагуу төлбөр тооцоог тогтоосон хугацаанд төвийн дансанд шилжүүлсэн дараа гэрээний дагуу үйлчилгээг үзүүлнэ.

6.5. Гэрээний дагуу төлбөрт үйлчилгээ үзүүлсэн тайланг хариуцсан алба нь Захиргаа, аж ахуйн албанд хагас, бүтэн жилээр тайлагнаж, архивд хувийг өгнө.

Долоо. Хориглох зүйл

7.1. Төвийн үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг бусад төсөвт байгууллагад шилжүүлэн зарцуулахыг хориглоно.

7.2. Төвийн бүх шатны удирдлага, эмч, ажилтнууд үйлчлүүлэгчдээс энэ журмын хавсралтад зааснаас бусад тусламж, үйлчилгээнд төлбөр авах, төлбөр тооцоог үйлчлүүлэгчтэй шууд хийхийг хориглоно.

7.3. Төлбөрт үйлчилгээний жагсаалтын төлбөрийн жишиг хэмжээнээс хэтэрсэн төлбөр нэхэмжлэх, авахыг хориглоно.

7.4. Эмч, ажилтнууд нь ажлын байрандаа хувийн журмаар үйлчлүүлэгчид төлбөртэй үйлчилгээ үзүүлэх, эм бэлдмэл худалдаалахыг хориглоно.

Найм. Хяналт, хариуцлага

8.1. Төлбөрт үйлчилгээ нь байгууллагын үндсэн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхгүй байх, төвийн үйл ажиллагааг доголдуулахгүй байхад анхаарч, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллах үүргийг төвийн дарга хүлээнэ.

8.2. Төлбөрт үйлчилгээний орлогыг Төсвийн тухай хууль, түүнд холбогдох журам болон энэ журмын дагуу зарцуулж байгаа эсэхэд дээд шатны байгууллага, төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн хяналт, дотоод аудит, төрийн аудит хяналт тавина.

8.3. Төвийн төлбөрт үйлчилгээний орлогыг үр ашиггүй зарцуулсан, мөн байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулж дараалсан хоёр улирлын төсвийн гүйцэтгэлийн

тайлангаар өр төлбөр үүсгэсэн бол хариуцлага алдсан албан тушаалтанд Төсвийн тухай хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

8.4. Төлбөрт тусламж үйлчилгээний талаарх үйлчлүүлэгчдийн өргөдөл, санал, хүсэлт, гомдлыг шийдвэрлэсэн болон орлого, зарцуулалтын тухай мэдээллийг нээлттэй ил тод байдлыг хангаж ажиллах үүргийг холбогдох албан тушаалтнууд хүлээнэ.

8.5. Энэхүү журмыг зөрчсөн албан тушаалтан, ажилтанд Хөдөлмөрийн дотоод журамд заасан сахилгын арга хэмжээ авч, хохирлыг буруутай этгээдээр төлүүлэн хөдөлмөрийн гэрээг цуцлах хүртэлх арга хэмжээг авна.

...oOo...

**ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУРГАЛТ, СУДАЛГААНЫ ЧИГЛЭЛЭЭР ҮЗҮҮЛЭХ
ТӨЛБӨРТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРӨЛ, ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ**



№	ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРӨЛ	ҮЗҮҮЛЭЛТ	Тоног төхөөрөмж, хугацаа	ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ		
				Эхний үзлэг	Давтан үзлэг	Бүлгээр хүн тутамд
1. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГААНЫ СОРИЛ, ТЕСТ, ШИНЖИЛГЭЭ						
1.1	Биеийн бүтэц, хэмжилт, тооцоолол (антропометрийн хэмжилт) хийх	<ul style="list-style-type: none"> • Биеийн жин /кг/ • Биеийн өндөр /см/ • Биеийн жингийн индекс /кг/м²/ • Биеийн өөхний хэмжээ %/ • Биеийн өөхний хэмжээ /кг/ • Гарын сарвууны атгалтын хүчний хэмжээ /кг/ 	Антропометрийн багажууд	15000	8000	12000
1.2	Биеийн дотоод бүтэц болон бодисын солилцоог тодорхойлох	<ul style="list-style-type: none"> • Биеийн ерөнхий бүтэц • Бүлчингийн масс, хөгжил, баланс • Бодисын солилцооны түвшин • Биеийн дотор өөхний хэмжээ • Шим тэжээлийн бодисын түвшин • Биеийн эрдэсийн хэмжээ • Таргалалт • Биеийн жингийн зохистой түвшин 	InBody төхөөрөмж	20000	10000	15000
1.3	Уушгигны /спирографик/ үзүүлэлтийг тодорхойлох	<ul style="list-style-type: none"> • Уушгины амьдралын багтаамж /л/ • Тифзногийн үзүүлэлт /л/сек/ • МВЛ үзүүлэлт /л/мин/ • Амьсгалын тооны дээд үзүүлэлт 	Cortex төхөөрөмж	30000	15000	20000

		<ul style="list-style-type: none"> • Гадна амьсгалын үр ашгийн хувь 				
1.4	Кардио-пульмональн ачаалалтай сорил	<ul style="list-style-type: none"> • Дээд туйлын хуч /Вт/ • Харьцангуй хуч /Вт/кг/ • Хүчилтөрөгчтэй нөхцөлд сорил гүйцэтгэсэн хугацаа • Хүчилтөрөгчтэй нөхцөлд сорил гүйцэтгэсэн ачаалал /%/ • Хүчилтөрөгчийн дээд хэрэглээний туйлын үзүүлэлт /мл/мин/ • Хүчилтөрөгчийн дээд хэрэглээний харьцангуй үзүүлэлт /мл/кг/мин/ • Хүчилтөрөгчийн дээд пульс /мл/1агшилт/ • Хүчилтөрөгчгүй нөхцөлд ачаалал авсан хугацаа • Хүчилтөрөгчгүй нөхцөлд сорил гүйцэтгэсэн ачаалал /%/ • Амьсгалын дээд хэмжээний коэффициент • Ачаалалтай зүрхний цахилгаан бичлэг /ЭКГ/ • Ачааллын үеийн артерийн даралт • Ачааллын үеийн зүрхний цохилт /ЧСС/ • Ачааллын үеийн сүүний хүчил /лактат/ 	Софтөх төхөөрөмж	60000	30000	45000
1.5	Сэргэлтийн үеийн үзүүлэлтийг тодорхойлох	<ul style="list-style-type: none"> • Артерийн даралтын тогтворжилт: • Зүрхний цохилтын тогтворжилт ЧСС /цохилт/мин/: • Зүрхний цохилтын нийлбэр /3 мин/цохилтын тоо/ • Сэргэлтийн үеийн зүрхний цахилгаан бичлэг /ЭКГ/ 	Софтөх төхөөрөмж	20000	10000	15000
1.6	Тайван үеийн бодисын солилцоог тодорхойлох	<ul style="list-style-type: none"> • Тамирчны тайван үеийн метаболизмын үйл ажиллагаа 	Софтөх төхөөрөмж	30000	15000	20000

	<ul style="list-style-type: none"> • Шинжлүүлэгчийн эрүүл мэндийн байдал • Ачаалалд зурх судасны системийн хариу үйлдэл • Биеийн туйлын болон харьцангуй ажиглах чадварын үнэлгээ • Хүчилтөрөгчийн үйлдвэрлэлт туйлын үнэлгээ • Хүчилтөрөгчтэй ачааллын хугацааны хувь • Хүчилтөрөгчийн дээд пульсын үнэлгээ • Хүчилтөрөгчгүй ачааллын хугацааны хувь • Амьсгалын дээд хэмжээний коэффициентын үнэлгээ • Сүүний хүчил /лактат/ өөрчлөлтийн үнэлгээ • Артерийн даралтын тогтворжилт хурдны үнэлгээ • Зүрхний цохилтын /ЧСС/-ын тогтворжилт хурдны үнэлгээ • Ачаалал ба сэргэлтийн үед хийсэн зүрхний цахилгаан бичлэгийн үзүүлэлтээр зүрхний бүлчингийн ачаалалд дасан зохицсон үнэлгээ 	Cortex Төхөөрөмж	40000	20000	25000
<p>1.7</p> <p>Биеийн ерөнхий эрүүл мэнд болон үйл ажиллагааны үнэлгээ хийх</p>	<ul style="list-style-type: none"> • Дээд мөчний үйл ажиллагааны тодорхойлолт • Дээд туйлын хүч вт, вт/кг, вт/сек • Биеийн жингийн кг тугамд ногдох хүч • Хүчний уналтын түвшин вт, вт/кг, вт/сек • Хамгийн бага хүч вт, вт/кг • Анаэробик нөхцөлд бүлчингийн ажиглах чадварын үзүүлэлт 	Mopark Ergoline Төхөөрөмж	25000	15000	15000
<p>1.8</p> <p>Дээд мөчний ажиглах чадварыг тодорхойлох сорил</p>	<ul style="list-style-type: none"> • Доод мөчний үйл ажиллагааны тодорхойлолт • Дээд туйлын хүч вт, вт/кг, вт/сек • Биеийн жингийн кг тугамд ногдох хүч • Хүчний уналтын түвшин вт, вт/кг, вт/сек • Хамгийн бага хүч вт, вт/кг • Анаэробик нөхцөлд бүлчингийн ажиглах чадварын үзүүлэлт 	Mopark Ergoline Төхөөрөмж	25000	15000	15000
<p>1.9</p> <p>Доод мөчний ажиглах чадварыг тодорхойлох сорил</p>	<ul style="list-style-type: none"> • Доод мөчний үйл ажиллагааны тодорхойлолт • Дээд туйлын хүч вт, вт/кг, вт/сек • Биеийн жингийн кг тугамд ногдох хүч • Хүчний уналтын түвшин вт, вт/кг, вт/сек • Хамгийн бага хүч вт, вт/кг • Анаэробик нөхцөлд бүлчингийн ажиглах чадварын үзүүлэлт 	Mopark Ergoline Төхөөрөмж	25000	15000	15000

1.10	<p>Хөдөлгөөний анализ, функциональ үнэлгээ хийх сорил</p>	<p>Ортогайт, Ногахон төхөөрөмж</p>	50000	30000	35000
1.11	<p>Сэтгэл зүйн сорил</p>	<p>Egoscope төхөөрөмж</p>	50000	30000	35000
<p>2. ТУСГАЙ БЭЛТГЭЛ ДАСГАЛЖУУЛАЛТ /СОПДИТОН СОАСНИНГ/</p>					
2.1	<p>Бэлтгэл дасгалжуулалтын зөвлөх үйлчилгээ</p>	<p>1 цаг</p>	50000	-	-
2.2	<p>Бэлтгэлийн нарийвчилсан төлөвлөгөө гаргах</p>		150000	-	-
2.3	<p>Ганцаарчилсан бэлтгэл дасгалжуулалт</p>	<p>1 сар</p>	150000	-	-

3. СЭТГЭЛ ЗҮЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ						
3.1	Сэтгэл зүйн байдлыг үнэлэх, оношлох	<ul style="list-style-type: none"> Тухайн тамирчны сэтгэл зүйн байдлыг үнэлж, оношлох 		25000	10000	15000
3.2	Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх	<ul style="list-style-type: none"> Тамирчинд сэтгэл зүйн зөвлөгөө өгөх 	1 цаг	40000	20000	20000
3.3	Сэтгэл заслын үйлчилгээ	<ul style="list-style-type: none"> Сэтгэл заслын цуврал ярилцлага хийх (8-10 удаа) 		200000	-	-
3.4	Хувь хүний онцлог, хөгжлийн талаарх зөвлөгөө өгөх	<ul style="list-style-type: none"> Тухайн тамирчны хувь хүний онцлогт тохирсон сэтгэл зүйн зөвлөгөө болон тамирчны карьер хөгжлийн талаар ганцаарчилсан зөвлөгөө өгөх 	1 цаг	25000	10000	15000
3.5	Бэлтгэлийн тэмдэглэл хөтгөлтөд анализ хийж зөвлөгөө өгөх	<ul style="list-style-type: none"> Тамирчны бэлтгэлийн үеэр хийх тэмдэглэлд зөвлөгөө өгөх, тэмдэглэл хөтгөлтөд дүн шинжилгээ хийх 		15000	-	10000
4. ХООЛ ЗҮЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ						
4.1	Биеийн дотоод бүтэц болон бодисын солилцоог тодорхойлох үзлэг	<ul style="list-style-type: none"> Биеийн ерөнхий бүтэц Булчингийн масс, хөгжил, баланс Бодисын солилцооны түвшин Биеийн дотор өөхний хэмжээ Шим тэжээлийн бодисын түвшин Биеийн эрдсийн хэмжээ Таргалалт Биеийн жингийн зохистой түвшин 	InBody төхөөрөмж			
4.2	Хоол зүйн үнэлгээний аппаратаар хийх үзлэг	<ul style="list-style-type: none"> Биед агуулагдах шим тэжээлийн бодисуудын түвшнийг тодорхойлох 		60000	30000	-
4.3	Хооллолтын судалгаа хийх	<ul style="list-style-type: none"> Тухайн хүний хооллолтын хэв маяг, дадал зуршил, хоолны цэсийг судалж, үнэлнэ 				
4.4	Хоол зүйн зөвлөгөө өгөх	<ul style="list-style-type: none"> Тухайн хүнд тохирсон зохистой хооллолтын талаар зөвлөгөө өгөхөөс гадна хоолны цэсийг гаргаж өгнө. 				
4.5	Хоол зүйн төлөвлөгөө гаргах	<ul style="list-style-type: none"> Тухайн хүнд тохирсон хооллолтын цогц төлөвлөгөөг гаргана. 				

5. СУРГАЛТ		
5.1	Тухайлсан сэдвээр ганцаарчилсан болон бүлгийн сургалтууд хийх	<ul style="list-style-type: none"> • Спортын анагаах ухаан • Спортын эрдэм шинжилгээ • Спортын хоол зүй • Спортын сэтгэл зүй • Спортын гэмтэл бэртэл, түүнээс урьдчилан сэргийлэх • Бэлтгэл дасгалжуулалт гэх мэт чиглэлээр сургалт зохион байгуулах
6. СУДАЛГАА		
6.1	Спортын шинжлэх ухааны тодорхой чиглэлээр захиалгат судалгаа хийх	<ul style="list-style-type: none"> • Спортын шинжлэх ухааны чиглэлээр спортын холбоод, хувь тамирчин, дасгалжуулагч болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн захиалгаар судалгаа, эрдэм шинжилгээний ажил хийнэ.
7. БАГЦ ҮЙЛЧИЛГЭЭ		
7.1	Эрдэм шинжилгээ, сургалт, судалгааны чиглэлээр үзүүлэх багц үйлчилгээ	<ul style="list-style-type: none"> • Спортын шинжлэх ухаан, эрдэм шинжилгээ, сургалт, судалгааны чиглэлээр хувь хүн, спорт холбоод, аж ахуйн нэгж дээр дурдсан үйлчилгээнээс 6 болон түүнээс дээш үйлчилгээг сонгосон тохиолдолд багц үйлчилгээ гэж үзнэ.
		Багц үйлчилгээний төлбөрийг тооцоходоо сонгосон үйлчилгээнүүдийн нийт төлбөрөөс 30 хүртэл хувиар хөнгөлөлт үзүүлнэ.

Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны даргын 2023 оны 03 дугаар сарын 07-ний өдрийн 1/06 дугаар тушаалын гуравдугаар хавсралт



СПОРТЫН АНАГААХ УХААНЫ ЧИГЛЭЛЭЭР ҮЗҮҮЛЭХ ТӨЛБӨРТЭЙ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРӨЛ, ТАРИФ

№	Тусламж үйлчилгээний жагсаалт	Төлбөрийн хэмжээ /төгрөгөөр /
Оношилгоо		
1.	Зүрхний цахилгаан бичлэг	15000
2.	Зүрхний ачаалалтай бичлэг	30000
3.	AWMаррег нурууны хазайлт мурийлт хэмжигч	50000
4.	Уушгины багтаамж хэмжих	5000
5.	Биеийн хэмжилтүүд хийх	10000
6.	Цусанд лактат тодорхойлох	15000
7.	Элэгний В вирусийн оношлуур	10000
8.	Элэгний С вирусийн оношлуур	10000
9.	SARS-COVID19 түргэвчилсэн оношлуур	25000
Нарийн мэргэжлийн эмчийн үзлэг		
1.	Зөвлөх эмчийн үзлэг, зөвлөгөө	50000
2.	Гэмтэл согог судлалын эмчийн үзлэг, зөвлөгөө	30000
3.	Дотрын өвчин судлалын эмчийн үзлэг, зөвлөгөө	30000
4.	Нөхөн сэргээхийн эмчийн үзлэг, зөвлөгөө	30000
5.	Спортын анагаах ухаан судлалын эмчийн үзлэг, зөвлөгөө	30000
6.	Уламжлалт анагаах ухааны эмчийн үзлэг, зөвлөгөө	30000
Нөхөн сэргээх, уламжлалт эмчилгээ		
1.	УВЧ шарлага	3000
2.	Татлага эмчилгээ: Хүзүү	10000
3.	Нуруу	10000-20000 /хугацаанаас хамаараад/
4.	Улаан гэрэл	3000
5.	Халуун жин	5000
6.	Хүйтэн жин	2000
7.	Лазер	5000-15000
8.	Цахилгаан эмчилгээ /-электрофорез эмчилгээ/	5000-10000
9.	Дууны долгион эмчилгээ	5000
10.	Соронзон долгионы эмчилгээ	10000-15000
11.	Цохилтот долгион эмчилгээ	30000-50000 /цохилтын тооноос хамаарна/

12.	Булчин суллах аппарат эмчилгээ /TENS/	5000-10000
13.	Дасгал эмчилгээ	10000
14.	Галт бумба 10 минут	10000
15.	Гар засал	10000
16.	Зүү эмчилгээ	15000
17.	Төөнүүр эмчилгээ	15000
18.	Хэсгийн бариа / толгой хүзүү,	15000
19.	Бүтэн биеийн бариа засал	40000
20.	Аарцаг нурууны бариа засал - 40 минут	50000
21.	Хануур засал	30000
22.	Шивүүр засал	30000
23.	Үенд тарилга хийх	50000
24.	Дусал тариа	5000
25.	Булчин тариа	3000
26.	Судас тариа	3000
27.	Тейп боолт болон наалт	10000-40000 /бүтэн үе эсвэл хэсэг газраас хамаарна/

---o0o---